



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 07

Бор-Өндөр

**“НЭЭЛТТЭЙ БОР-ӨНДӨР СУМ” ДЭД
ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөлчдийн Хурлын арван долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших, иргэд аж ахуй нэгжийг дэмжих “Нээлттэй Бор-Өндөр сум” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Г.Адъяабилэгт)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын хорооны дарга (Ж.Энх-Оргил)-д даалгасугай.

ДАРГА  Д.ОТГОНЦЭЦЭГ

